

## БАНКНЫ САЛБАР ДАХ ИННОВАЦИ ТҮҮНИЙ ҮР АШГИЙГ ҮНЭЛЭХ БОЛОМЖ

Ө.Гэрэлт Од\*

**Хураангуй:** Банкны салбарын хөгжлийг хөрөнгийн өсөлт ба үр ашгаар хэмжих бөгөөд түүнийг тогтвортой байдлыг хангахад салбар дах технологи, инновацын асуудал чухал байр суурийг эзлэж байна. Уламжлалт банкны үйлчилгээ технологийн ололтод суурилан хөгжин шинэчлэгдэж байгаа нь банкны үйлчилгээний хүртээмж, хэмжээг нэмэгдүүлэх төдийгүй, банкны бизнесийн үр ашгийн хэмжээнд нөлөө үзүүлэхүйц хүчин зүйл болж байна. Нөгөө талаар банкны үйлчилээний технологийн хөгжил харилцагчийг хөгжүүлэн, технологид суралцах хүчин зүйл болж байна. Банкны салбарын хөгжлийн хүчин зүйл болсон инновацийн санхүүжилтийн зохистой байдал, үр ашгийг үнэлэх асуудал нь салбарын тулгамдсан асуудлуудын нэг юм. Иймд банкны салбарын инновацийн өнөөгийн байдлыг өөрийн орны болон бусад улсын жишээн дээр судлан, түүний үр ашгийг тооцох үзүүлэлтүүдийг тооцох боломжийг уг ажилд авч үзсэн болно.

**Түлхүүр үгс:** банкны салбар дах инноваци, инновацын үр ашгийн шинжилгээ

Банкны инноваци, ОУ-ын туршлага. Банкны бизнесийн хөгжлийг хөрөнгө ба харилцагчийн тоон өсөлтөөр хэмждэг ойлголт нэгэнт хуучирч үйлчилгээний чанар, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл зэрэг үзүүлэлтээр үнэлэх болжээ. Банкны бизнесийн хөгжлийн үндсэн концепци технологийн дэвшилд суурилж байгаа ба технологийн дэвшил нь банкны үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, харилцагчдыг татах гол арга болж байна.

Судлаачид банкны инноваци гэдгийг орчин үеийн технологийн дэвшилд тулгуурласан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон зах зээлд, хэрэглэгчдэд хүргэх үйл явц, технологийн дэвшлийг нийгмийн хэрэгцээнд зориулах нь түүний эцсийн зорилго гэж тодорхойлсон байдаг. Иймд банкны үйлчилгээний

---

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) gereltod.u@gmail.com

технологийг сайжруулах нь түүний хөгжлийн үндсэн гарц болоод зогсохгүй банк болон харилцагчдыг шинжлэх ухаан, техник технологийн ололттой танилцуулан тэдгээрийг хэрэглээнд сургаж байгаагаараа банкны нийгэмд үзүүлж буй тус дэмжлэгийн хэлбэр юм.

### **Банкны инновацийг:**

1. Банкны дотоод зохион байгуулалтын,
2. Банкны гадаад ажиллагаа зохион байгуулалтын,
3. Өргөн хүрээнд буюу гадаад зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг байна.

Банкны харилцагчдад үзүүлж буй үйлчилгээ зөвхөн өөрийн харилцагчдаар хязгаарлагддаггүй, бусад банкны харилцагчид ч дэвшилт үйлчилгээг танин мэдэж ашигладаг онцлогтой. Энэ нь банкууд үндэсний болон олон улсын банкуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгодог ба түүнийг хэрэгжүүлэхэд технологийн түвшин чухал үзүүлэлт болдог. Иймд банкууд гадаад зах зээлд чиглэсэн технологийн сайжруулалтыг корреспондент банкны технологид түшиглэн хэрэгжүүлдэг байна.

Банкны инновацийг бизнесийн зорилгоор ашиглахаас гадна инновацийн үйл явцыг дэмжин зээлийн багцын багагүй хэсгийг технологийн хөрөнгө оруулалтанд байршуулдаг.

### **Олон улсын түвшинд банкны инноваци нь:**

- IT буюу мэдээллийн технологийг банкны бизнест нэвтрүүлэх чиглэлээр,
- Банкны шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээний технологийг боловсронгуй болгох чиглэлээр,
- Банкны шинэ төслийг дэмжих гэсэн чиглэлээр банкны үйл ажиллагаанд нэвтэрч банкны хөгжлийг хурдасгагч болж байна.

Bankers сэтгүүлээс банкны инновацийн шинэлэг санаа, санаачлагыг байнга шалгаруулдаг бөгөөд банкны технологийн чиглэлээр SMS banking / Short message services/, банкны шинэ төсөл санаачлагын чиглэлээр Eco bank, Green banking төслүүд, бичил зээл хөтөлбөрүүд банкны инновацийн шагналаар шагнагдсан байна. Тус сэтгүүл банкны инновацийг хөгжүүлэх, түүнийг салбарт таниулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ба 2016 онд банкны инновацийн тэргүүн шагналыг “Anoto digital pen and paper technology” төсөл авсан байна. Энэ технологи нь харилцагч ба банк баримт бичгүүдтэй харилцан танилцах, тэдгээрийг дамжуулахад зарцуулах хугацаа хэмнэх, өртөг буурах ач

холбогдолтой төсөл гэж үзэж ийнхүү шагнажээ. Мөн АТМ машины байршлыг ашиглалт, эрсдэл буюу хулгай, тээвэрлэлт, хяналт, тэдгээрийн мэдээлэл дамжуулах сүлжээний оновчтой бүтэцийг бий болгох семуляцын ажил, банкны мэдээлэл хамгаалалт, нууцлалын системийг бий болгох платформ боловсруулах зэрэг ажлууд банкны салбар дах инновацийн шагналыг хүртсэн байна.

Олон улсын түвшинд банкныг инновацийг хөхүүлэн дэмжигч байгууллага буюу банкны бизнесийг “Оюунлаг” гэж тодорхойлох болсон байна. Банкны үйлчилгээний технологийг “PC banking technology” хэмээн тодорхойлох болсон ба hardware, software, telecommunication ашиглан харилцагчдад банкны үйлчилгээг хүргэхээс гадна өрх гэр болон банкны бусад харилцагчдад: Dial up services /PC modem/, Home Finance software /Microsoft’s Money, Bank of America’s MECA software/, On-line Services-based технологийг ашиглаж, эдгээр технологийг хэрэглэгчдэд хүргэх, хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж байна.


Банкны зах зээлд шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ харилцагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгааны үр дүнг үндэслэх ба хэрэглэгч, нийлүүлэгчийн хувьд үйлчилгээний технологийг боловсруулан нэвтрүүлдэг байна. Банкны гадаад ба дотоод хэрэглэгчид, зөвлөхүүд, гүйцэтгэх ажилтан буюу банкны үйлчилгээний ажилтан нарын санал, дүгнэлтийг бүтээгдэхүүн үйлчилгээний технологи, стандартыг боловсруулахдаа ашигладаг нь хэрэглэгчийн ба банкны зүгээс шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд хүргэх бэрхшээлийг бууруулдаг байна.

Зураг 1. Банкны технологи нэвтрүүлэх үйл явц.



Банкны үйлчилгээний технологи хөгжих тусам банкны үйлчилгээг харилцагчдад эзэмшүүлэхэд банкууд анхаарч ажиллах болсон байна. Банкны үйлчилгээний технологийг харилцагчдад хүргэх ажиллагааг зөвхөн

харилцагчдыг сургах гэдэг ойлголтоор хязгаарладаггүй, “судалгаа ба хөгжил” R&D хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. R&D /research & development/ нь бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх технологийг боловсруулахаас гадна бүтээгдэхүүний маркетингийг боловсруулж, зах зээлд нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлдэг байна. Банк харилцагчдыг үйлчилгээний технологид сургах тогтолцоог “Хамтын ажиллагаа ба инноваци” гэж тодорхойлдог. /Зураг 1/



Банкны шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд системийн ерөнхий хянагч, зохицуулагчийн үүрэг их бөгөөд зах зээлд оролцогчдийн хооронд хийгдэх санхүүгийн зуучлалыг зохицуулан зохион байгуулах, технологийн жигдрэлийг хангахад гол зохицуулалтыг хэрэгжүүлдэг байна. Мөн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж дэмжлэг үзүүлэх нь системийн бодлогын байгууллагын үндсэн үүрэг юм. Өөрөөр хэлбэл системийн технологийн хөрөнгө оруулалт нь бодлогын байгууллагаас системийн байгууллагад үзүүлдэг гол дэмжлэг гэж болно.

### **МУ-ын банкны салбар дах инновацийн өнөөгийн байдал**

Манай улсын банкны салбарт хийгдэж буй инновацийн чиглэл дэлхийн улсуудын банкны салбарын технологийг дэвшлийг даган хөгжиж байна. Банкны салбар дах технологийн хөрөнгө оруулалт нь төлбөр тооцооны системийн дэд бүтэцийг сайжруулах чиглэлд голчлон хийгдэж байгаа ба төлбөрийн карт, түүний технологийн чиглэлээр, хөдөлгөөнт банкны үйлчилгээ буюу мобайл, интернет банкны технологийн чиглэлд хийгдэж буй хөрөнгө оруулалт нь төлбөрийн системийн хөгжилд өөрийн зохих хувь нэмрийг оруулж байна.

МУ-ын банкны салбар дах инновацийг i) технологийн буюу тоног

төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр хийгдэж буй хөрөнгө оруулалт, ii) шинэ бүтээгдхүүн үйлчилгээг бий болгох, iii) технологи дэмжих, нууцлал хамгаалалтын програм хангамжийн чиглэлд хийгдэж буй хөрөнгө оруулалт гэж ялгаж үзэж болох юм. Техник технологийг гадаад зах зээлээс шууд худалдан авахаас гадна өөрийн дотоодод хөгжүүлэх хэлбэрээр хөрөнгө оруулалтыг хийж байна.

Уламжлалт банкны үйлчилгээ-Телефон банкны үйлчилгээ-Интернет банкны үйлчилгээ-Мобайл банкны үйлчилгээ гэсэн үйлчилгээний технологийг шинэчлэл нь банкны салбар дах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. МУ-ын банкны технологийн хөгжилд МУ-ын холбоо мэдээллийн дэд бүтэцийн хөгжил чухал нөлөөтэй. Өнөөгийн байдлаар МУ-д интернет хэрэглэгчийн тоо 2512,7 мянга байгаа бөгөөд 300 сум суурин газар өндөр хурдны интернетийн сүлжээнд хамрагдсан байна. Энэ нь манай төлбөрийн системийн дэд бүтэцийг бүрдүүлэхэд тулгуур хүчин зүйл болж байгаа ба банкны үйлчилгээнээс алслагдсан сум суурийн газрууд бодит цагийн горимоор төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлжээ.

2016 оны байдлаар давхарсан тоогоор 2,7 сая хэрэглэгч Мобайл банкны үйлчилгээг ашиглаж байгаа ба түүнээс 1,3 сая хэрэглэгч нь идэвхтэй хэрэглэгч байгаа, 1,1 сая интернет банкны хэрэглэгч бүртгэгдсэнээс 473,3 мянга нь идэвхтэй хэрэглэгч, төлбөрийн карт хэрэглэгчийн тоо 4 саяд хүрсэн ба үүний 1,5 сая нь идэвхтэй хэрэглэгч байгаа<sup>2</sup> зэрэг нь хүн амын тоотой харьцуулахад 3 хүн тутамын нэг нь хөдөлгөөнт банкны ямар нэг үйлчилгээг ашигладаг ба 2016 онд нэг өдөрт дунджаар 6.8 тэрбум төгрөгийн 170.2 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, өдөрт дунджаар 7.7 тэрбум төгрөгийн, 179.7 мянган ширхэг картын гүйлгээг тус тус дамжуулсан байгаа нь хэрэглэгчид банкны үйлчилгээний технологийг хэрэглээний түвшинд ээмшсэн болохыг харуулж байна. Банкны цаашдын технологийн хөгжлийг цахим орчинд хөгжинө гэж тодорхойлж байгаа ба энэ нь банкуудын технологийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, чанаржуулах шаардлагыг бий болгож байна.


Мобайл банкны эрх бүхий хүний тоо давхардсан байдлаар 2015 онд нийт хүн амын 73,18% байсан бол 2016 онд 87,88% болж өссөн ба идэвхтэй хэрэглэгчийн тоо 28,67-43,2% болж өссөн байна. Интернет банк хэрэглэгчийн тоо мобайл банк хэрэглэгчийн тоотой харьцуулахад харьцангуй цөөн бөгөөд 2015 оны байдлаар нийт хүн амын 28,6% интернет банк банкны эрх эзэмшин

---

2 Монгол банкны мэдээлэл 2017/II

4,1% идэвхтэй ашиглаж байсан бол 2016 онд нийт хүн амын 33,8% эрх эзэмшин 15,17% нь интернет банкны үйлчилгээг идэвхтэй ашиглаж байна.

Зураг 3. Интернет банк, мобайл банкны эрх эзэмшигч ба хэрэглэгчийн судалгаа




Эх сурвалж: Монгол банк. Хөдөлгөөнт банкны тайлан 2015.IV, 2016.IV


Интернет банк хэрэглэгчийн тоо мобайл банк хэрэглэгчийн тооноос харьцангуй цөөн байгаа нь үйлчилгээний технологийн нөхцөлөөс хамаарч байгаа бөгөөд интернет холболт шаардахгүйгээр шууд мобайл сүлжээ ашиглан төлбөр тоцоо хийх нь хэрэглэгчдийн хувьд илүү хялбар хэрэглээ болсон гэдгийг харуулж байна. Гэхдээ интернет банк хэрэглэгчийн тооны өсөлт мобайл банк хэрэглэгчийн тооны өсөлтөөс хурдан байгаа ба 2016 онд мобайл банк идэвхтэй хэрэглэгчийн тоо 53%-аар өссөн бол интернет банк эзэмшигчийн тоо 2,7 дахин өссөн байна. /Зураг 3./

2015-2016 онд засаг захиргааны бүх нэгжээр мобайл банкны эрх эзэмшигч болон идэвхтэй хэрэглэгчийн тоо өссөн нь шинэ үйлчилгээний технологи хэрэглэгчдийн хувьд нутагшиж байгааг харуулж байгаа үзүүлэлт юм. 2015 онд нийт хүн амын 28,7% , 2016 онд 44,92% мобайл банкны идэвхтэй хэрэглэгч болсон байна. Энэ үзүүлэлтийн улсын дундаж 2015 онд 32,49% 2,16 онд 44,92 % болж өссөн ба улсын хэмжээгээр Өмнөговь аймгийн хүн амын /2016 оны байдлаар/ 70,49% мобайл банкны үйлчилгээг ашиглаж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Интернет банкны үйлчилгээг 2015 онд нийт хүн амын 4,12% ашиглаж байсан бол 2016 онд 15,17% болж өссөн ба Улаанбаатар хотын хүн амын 29,1% /2016 оны байдлаар/ интернет үйлчилгээг ашиглаж буй хамгийн өндөр үзүүлэлт юм.

Зураг 4. Мобайл банк хэрэглэгчдийн тоо /аймгаар, хүн амын тоонд харьцуулснаар/



Зураг 5. Интернет банк хэрэглэгчийн тоо /аймгаар, хүн амын тоонд харьцуулснаар/



Эх сурвалж: Монгол банк. Хөдөлгөөнт банкны тайлан 2015.IV, 2016.IV  
-www.1212.mn. Хүн амын статистик тоо мэдээлэл

### **Инновацийн үр ашгийг үнэлэх нь.**

Банкны технологийн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлоход бодлогын байгууллагын оролцоо чухал ач холбогдолтой. Банкуудын технологи жигдэрснээр төлбөрийн системийн технологи жигдрэх нөхцөл бүрдэх ба төлбөр тооцоо найдвартай, тасралтгүй хэрэгжих, дамжуулалтын зардал буурах зэрэг эерэг үр дүнг бий болгодог. Банкуудын технологийн хөгжил нь тухайн чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээгээ тасралтгүй өсгөх шаардлагыг бий болгож байна. Эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байх, технологийн хөгжлийн хувьд бусад банкуудтай өрсөлдөхүйц жигд түвшинг хангахуйц байх нөхцөлийг хангах түвшинд хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Банкны зах зээл дэх инновацийн үр ашгийн талаар V.Prasad, T.Harker (1997) нар АНУ-ын иргэдийн банкны салбарын бүтээмжийг мэдээллийн технологийн хүчин зүйлс талаас нь судласан ба уг судалгааны ажлын үр дүнгээр технологийн хөрөнгө оруулалт нь хөдөлмөрийн бүтээмж нь үйлдвэрлэлийн хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ, банкны хувьд технологийн хөрөнгө оруулалт нь бусад хөрөнгө оруулалтаас үр ашиг өндөр гэж тодорхойлсон байдаг.

АНУ-ын банкууд инновацийн чиглэлээр хийгдэж буй хөрөнгө оруулалт банкны хүүний бус зардлын 20%-иас багагүй байхаар хөрөнгө оруулалтын бодлогодоо тусгадаг нь банкууд мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн өнөө үеийн технологийн шинэчлэлээс хоцрохгүй байх арга нь болдог гэж үздэг.

Банк инновацийг нэвтрүүлснээр зардлын хэмжээ өсөх боловч түүний үр дүнд орлогын хэмжээ түүнээс илүү хувиар өснө гэсэн хүлээлттэй байдаг. Банкны хувьд инновацийн үр ашгийг үнэлэхдээ мэдээллийн технологид оруулсан хөрөнгө оруулалтын зардлын хувийн жин, нийт бүтээгдхүүн үйлчилгээний хэдэн хувь нь ямар технологи ашиглагдаж хийгдсэн үйлчилгээ байгаа зэрэг үзүүлэлтийг ашиглахаас гадна түүний үр ашгийг бүтээгдхүүн, технологи тус бүр дээр тооцох, инновацийн хөрөнгө оруулалтын үр ашгийг оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, холбогдон гарах зардал, орлого зэрэг үзүүлэлтийг ашиглан тооцдог байна. Мөн технологи нэвтрүүлэлтийн зардал буюу зар сурталчилгаа сургалт, технологи ашиглалтын зардлаас гадна ажиллах хүчний зардал, бүтээмжийн өсөлт зэргийг харьцуулан авч үзэх нь зүйтэй.



## Хүснэгт 1. Банкны салбар дах инновацийн үр ашгийг үнэлэх үзүүлэлтүүд

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТООЦООЛОЛ
1	Банкны нийт зардалд ИТ-ын зардлын эзлэх хэмжээ	$K_1 = \frac{IT \text{ зардлын хэмжээ}}{\text{Нийт зардал}}$
2	Хүүний бус зардалд ИТ-ын зардлын эзлэх хэмжээ	$K_2 = \frac{IT \text{ зардлын хэмжээ}}{\text{Хүүгийн бус зардал}}$
3	Инновацийн хөрөнгө оруулалтын түвшин	$K_3 = \frac{IT \text{ тоног төхөөрөмж}}{\text{Үндсэн хөрөнгө}}$
4	Нийт хөрөнгөд мэдээллийн технологийн хөрөнгийн хэмжээ	$K_4 = \frac{IT \text{ тоног төхөөрөмж}}{\text{Нийт актив}}$
5	Инновацийн үр ашиг	$K_5 = \frac{IT \text{ технологи ашиглуулж олсон орлого}}{\text{Нийт орлого}}$
6	Инновацийн шууд зардал ба орлогын харьцаа	$K_6 = \frac{IT \text{ технологи ашиглуулж олсон орлого}}{IT \text{ технологийн сайжруулалтын зардал}}$

Өнөөгийн байдлаар олон улсын түвшинд ашиглаж байгаа дээрх үзүүлэлтүүдийг манай улсын банкуудын нийтэд зориулсан тайлангаас тодорхойлох боломжгүй байгаа бөгөөд дотоод тайланд дэлгэрэнгүй тусгадаг байхыг үгүйсгэхгүй.

## Хүснэгт 2. Банкуудын санхүүгийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Хаан банк			Голомт Банк		
	001 он	002 он	Өсөлт	001 он	002 он	Өсөлт
1. Картын үйлчилгээний орлого	11874.49	13591.88	14%	8,946.87	9,658.64	8%
2. Тоног төхөөрөмж	38,738.35	41,025.08	6%	21,126.11	9,196.19	-56%
3. Биет бус хөрөнгө	14,270.61	7,779.11	-45%	9,004.52	14,062.69	56%
4. Картын үйлчилгээний зардал	1,800.91	2,100.41	17%	4,178.02	4,599.83	10%
5. Картын үйлчилгээний үр ашиг	6.59	6.49		2.14	2.1	

Эх сурвалж: Хаан банкны санхүүгийн тайлан 2014-2015 он  
Голомт банкны санхүүгийн тайлан 2014-2015 он

Банкны инновацийн хөрөнгө оруулалт гэдэгт тоног төхөөрөмжийн ба програм хангамжийн чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ойлгож болох ба тэдгээрт гарсан өөрчлөлтийн хэмжээгээр хөрөнгө оруулалтын хэмжээг

тодорхойлж болох юм. /Хүснэгт.2/ Банкуудын инновацийн чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлыг Хаан ба Голомт хувьд авч судлан үзлээ. Биет хөрөнгийн хувьд Хаан банкны тоног төхөөрөмжийн үлдэгдэл 6% өссөн, Голомт банкных 56% буурсан, биет бус хөрөнгийн үлдэгдэл Хаан банк 45%-аар буурсан, Голомт банк 56% өссөн үр дүнг харуулж байна. Биет ба биет бус хөрөнгийн ашиглалтын балансын үлдэгдэл буурч байгаа нь хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусч шинээр хөрөнгө оруулалт шаардагдаж байгааг харуулж байна.

Банкуудын салбарын тоо, үйлчилгээний төрөлжилтөөс хамааран технологийн хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ харилцан адилгүй байдаг. Тухайлбал Хаан банкны салбарын тоо Голомт банкнаас 3 дахин илүү тул ашиглалтанд шаардлагатай тоног төхөөрөмжийн хэмжээ төдий хэмжээгээр их байх хэрэгцээг бий болгожээ.

Банкуудын картын үйлчилгээг үр ашиг өндөртэй бүтээгдхүүн гэж үзэж болох бөгөөд Хаан банк 1 төгрөгийн зардал зарж 6,49-6,59 төгрөг, Голомт банк 2,1-2,4 төгрөгийн орлогыг тус тус олсон байна. Тухайн бүтээгдхүүний үр ашгийн түвшин харилцан адилгүй байгаа ба энэ карт эзэмшигчдийн тоо, тоног төхөөрөмжийн хүрэлцээ зэргээс хамаарч байгаа болно.

### **Дүгнэлт**

Манай улсын банкны салбарын хөгжилд инноваци зайлшгүй хүчин зүйл бөгөөд түүнийг бодлогоор дэмжих асуудалд Монгол банк анхаарлаа хандуулан банкны салбар дах инновацийн бодлого хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай байна. Энэ нь банкуудын технологийг жигдрүүлэн, салбарын дэд бүтцийг сайжруулах төлбөр тооцооны системийн хэвийн найдвартай байдалд эерэг нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болно.

Банкны инновацийн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхдээ бодит мэдээлэл, шинжилгээний үр дүнд суурилах, үүний тул нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг боловсронгуй болгох замаар мэдээллийн баазийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Тоног төхөөрөмж, технологийн төрөл тус бүрээр орлого зардал, нэвтрүүлэлтийн зардлыг нарийн тодорхойлох шаардлагатай юм. Нэвтрүүлэлтийн зардал гэдэгт технологийн тоног төхөөрөмж, дагалдах програм хангамж, тэдгээрийн ашиглалтын болон ажиллах хүчний зардал, технологийг харилцагчдад

хүргэх зар сурталчилгаа, сургалтын зардлуудыг ойлгоно. Мэдээлийн баазыг бүрдүүлснээр хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх, харьцуулах боломж бий болох, нэгж үйлчилгээ тус бүрийн хөдөлмөрийн ба технологийн зардал, хүний оролцоотой ба ба техникийн оролцоотой бүтээгдхүүний өртөг зардлыг харьцуулан судалж инновацийг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлох боломж бий болох тул банкууд уг ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

#### **Ашигласан материал:**

1. Монгол банкны мэдээлэл. 2017.I
2. Монгол банк. Хөдөлгөөнт банкны тайлан 2016.I, 2017.I
3. Банковские инновации: Мировой опыт и Российская практика. Муравьева.А.В 2005 г.
4. Направления инновационной деятельности коммерческих банков на современном этапе развития экономики. Галкин.Д.Э, Анащенко.А.Г. 2006 г
5. Управление банковскими инновациями. Е.В. Молчанова. 2007 г
6. Information System Investment, Productivity and Efficiency in Japanese Banking Industry. Toshihiko Takemura. 2010.
7. [www.1212.mn](http://www.1212.mn)